

## ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН ЭЭЛЖИЛТ УУЛЗАЛТ БА МОНГОЛ УЛС Д.ӨЭЛҮН-ҮЖИН\*

Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын Зөвлөлийн ээлжилт уулзалт Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо 2007 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр болж өнгөрлөө.

Уг уулзалтанд Узбекистан улсын ерөнхий сайд Шавкат Мирзияев, Хятадын төрийн тэргүүн Вэн Зябао, Киргизстан улсын ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Алмаз Атамбаев, ОХУ-ын ерөнхий сайд Виктор Зубков, Тажикстан улсын ерөнхий сайд Акил Акилов, Казахстан улсын ерөнхий сайд Карим Масимов нар оролцов.

Уулзалтын эхэнд төрийн тэргүүнүүд гишүүн орнуудын худалдаа эдийн засгийн болон хүмүүнлэгийн үйл ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, гишүүн орнуудын эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулахаа мэдэгдсэний зэрэгцээ 2006 онд Душанбе хотноо хуралдсан ШХАБ-ын гишүүн орнуудын эдийн засаг хүмүүнлэгийн хамтын ажиллагаа өргөжин хөгжиж, төсөл төлөвлөгөө амжилттай биелэж байна гэдгийг цохон тэмдэглэсэн байна.

Мөн 2007 оны 10 дугаар сарын 24-нд Астана хотод хуралдсан гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвөлгөөнөөр тус байгууллагын гадаад эдийн засаг болон гадаад худалдааны үйл ажиллагааг хариуцсан сайд нар улс хоорондын худалдаа эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн хэмээн дүгнэжээ.

Хуралдааны үеэр эдийн засгийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэн хөгжүүлэхийн тулд худалдаа эдийн засгийн олон талт ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөг ажлын тусгай хэсгүүдээр гаргуулан мөрдүүлэхийг Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын

нарийн бичгийн газар болон Ахлах Комисст үүрэг болгов.

Уулзалтаар гишүүн орнуудын гадаад худалдаа, энхтайвныг хөхүүлэн дэмжих, аюулгүй байдал, бүс нутгийн хөгжил болон тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулсан бөгөөд хуралдаанаар хилийн хамтын ажиллагааны гэрээнд талууд гарын үсэг зурсан нь ШХАБ-ын гишүүн орнуудын хувьд томоохон алхам болсон төдийгүй энэ нь тус байгууллагын гишүүн орнуудын худалдаа эдийн засгийн харилцаа сайжрахад чухал тус нэмэр болох юм.

ШХАБ-ын Бизнесийн зөвлөл болон шинээр байгуулагдсан Банк Хоорондын Нэгдлийн хамтын ажиллагаанд түлхэц өгөх, эдийн засгийн зорилт болон үр дүнг эрх тэгш байлгах талаар уг байгууллагын хүрээнд ажлаа эрчимжүүлж байна.

2007 оны 6 дугаар сарын 29-нд Москва хотноо болсон эрчим хүчний салбарт хамтран ажиллах, тэр дундаа гишүүн орнуудын үндэсний стратегийн талаар анх удаа төрийн тэргүүнүүдийн уулзалт болсонд гишүүн орнуудын эрчим хүч хариуцсан сайд нар өндөр үнэлэлт өгчээ.

Мөн тус уулзалтын үеэр ОХУ-ын Үйлдвэрлэл болон Эрчим хүчний яамны орлогч сайд Иван Матеров Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын “Эрчим хүчний Клуб” –ийг 2008 онд байгуулахаар төлөвлөж байгаа болон уг клубыг байгуулах баримт бичигт ОХУ аль хэдийн гарын үсэг зурсан тухай сэтгүүлчдэд мэдэгдсэн байна.

Уулзалтын үеэр төрийн тэргүүнүүд хүрээлэн буй орчныг хамгаалах талаар хамтран ажиллах, тэр дундаа бүс нутгийн усны хүчийг эрчим хүч болгох талаар хийгдэж буй төслийг тус тус авч хэлэлцжээ.

\* Д.Өүлэн-Үжин. ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Тус хуралд Монгол, Пакистан, Энэтхэг, Иран, Туркменстан, Афганистан зэрэг орнууд ажиглагчаар оролцсон бөгөөд хоёр дахь өдрийн үдээс хойшхи өргөтгөсөн хуралдаанд манай төлөөлөгчдийн тэргүүн М.Энхсайхан оролцож удирдамжийн дагуу товч үг хэллээ. Тэрээр “Хэдийгээр ШХАБ байгуулагдаад удаагүй боловч бүс нутгийн хамтын ажиллагаанд өөрийн гэсэн байр суурьтай болж байгаа”-г цохон тэмдэглэхийн сацуу Монгол Улс энэхүү байгууллагад өөрийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө байдгийг илэрхийлж, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, ХАА зэрэг салбарт хэрэгжүүлэхээр төсөвлөж буй төслүүдэд оролцох хүсэлтэй буйгаа мэдэгдлээ. Түүнээс гадна бүсийн улс орнуудын хооронд болж байгаа үйл ажиллагаанд оролцох сонирхолтой байгаа болон Төв Азийн орнуудын хооронд эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд манай баруун бүсийн зам, дэд бүтцийг хөгжүүлэх нь чухал болох талаар дурдсан байна.

Мөн Монгол Улс ШХАБ-ын дээд хэмжээний уулзалт, Засгийн газрын тэргүүн нарын болон Гадаад хэргийн сайд нарын уулзалтад ч оролцож байгаа мэдэгдэж, Бизнесийн зөвлөл, Банк хоорондын Нэгдлийн үйл ажиллагаанд оролцох эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

ШХАБ-ын гишүүн орнуудын уулзалтын үеэр гол анхаарлаа хандуулан, яригдаж буй хамгийн чухал асуудал бол гишүүн орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал нь уг уулзалтад ажиглагчийн статустай манай улсын сонирхлыг зүй ёсоор татаж байгаа юм. Гэхдээ зөвхөн ажиглагчийн статустай оролцдог манай улсын хувьд эдийн засгийн хөгжлийг дэмжих уг төслүүдэд хараахан оролцох боломжгүй.

ШХАБ-д гишүүнээр элсэх нь Монгол Улсын эрх ашигт нийцэх, эс нийцэх талаар манай улс төрчид, судлаачид янз бүрийн байр суурьтай явж ирсэн билээ.

Тус байгууллагад оройлох үүрэгтэй манай хоёр хөрш ОХУ, БНХАУ нь Монгол Улсыг тус байгууллагад гишүүнээр элсүүлэх ихээхэн сонирхолтой байдаг. Энэ сонирхол нь Монгол Улсыг өндөр хөгжилтэй орнуудтай олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, тэр дундаа АНУ-тай харилцах харилцаагаа улам эрчимжүүлэхийн хэрээр

нэмэгдэж байна.

Монгол Улсыг ШХАБ-т элсүүлэх БНХАУ-ын сонирхлын нэгээхэн хэсэг нь манай улс Хятадын хувьд буфер улсын /buffer zone/ үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд үүнийгээ ШХАБ-аар дамжуулан хэрэгжүүлэх явдал юм. Мөн үүнээс гадна АНУ-ын дангаар ноёрхох ноёрхлыг сулруулах, давамгайллыг хязгаарлахын тулд ШХАБ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилго бол Хятадын стратегийн гол зорилтуудын нэг хэмээн гадаадын хэвлэлд бичиж байна.

Манай улс ШХАБ-д элсэн орсноор гишүүн орнуудын харилцан эдийн засгийн үзүүлэлтээ дээшлүүлэх төсөл хөтөлбөрт оролцох сайн талтай боловч үүнийг дагаад гол гишүүн орон болох БНХАУ-ын эдийн засгийн шууд хараат байдалд орох аюултай төдийгүй гуравдахь түнш орнуудтай харилцах харилцаанд шууд бусаар таагүй байдал үүсгэх, ШХАБ-аар дамжуулан Монгол дахь АНУ-ын нөлөөг багасгах магадлалтай юм.

Монгол Улс ОХУ, БНХАУ хэмээх хоёр их гүрний дунд оршдогийн хувьд тэдний явуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь зүйн хэрэг боловч энэ нь манай улсын үндэсний эрх ашигт сөргөөр нөлөөлөх хүчин зүйл байж болох талтай.

Гэвч одоогийн байдлаар ШХАБ-ын байр суурь, хөгжлийн чиг хандлага төдийлөн тодорхой бус байна.

Хэрэв манай улс тус байгууллагад элсэх тохиолдолд ямар чиглэлээр, хэрхэн хамтарч ажиллах талаар судлаач, эрдэмтдийн гаргасан судалгааг үндэслэж тодорхой шийдвэр гаргах хэрэгтэй болов уу. Үүний зэрэгцээ энэ байгууллагын үйл ажиллагаанд байнга анхаарал тавьж ажиглагчийн байр сууринаас ч болов оролцож байх нь манай орны хувьд чухал юм. ШХАБ-ын гишүүн орнуудын ээлжит уулзалтыг 2008 онд Казахстан улсад хийхээр товложээ.

#### Эшлэл зүүлт:

1. [www.tajiknews.com](http://www.tajiknews.com)
2. [www.sectesco.org](http://www.sectesco.org)
3. [www.abc.com](http://www.abc.com)
4. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2006 он ГХЯ УБ
5. “Төв Азийн геополитик ба Монгол Улс” 2005 он УБ, ред, К.Дэмбэрэл
6. [www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn)